



МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,220,198...



УСХ-ны өчигдрийн мэдээгээр

Худалдах үнэ 500 төг

2018.08.14. Мягмар. №136 (4986)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ



- "Дэлхийн сонины холбоо"-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин

www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongolinmedeesonin@gmail.com

20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Нэргүйн ПУНЦАГБОЛД

ОНЦЛОХ МЭДЭЭ

НӨЛӨӨТ ТОЛЬ

13 настай охины гэр бүл шинэ байшинтай болно

С.БУДРАГЧАА

Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороонд байрлах "Очир" төвд бусдын гарт хэрцгийгээр хөнөөгдсөн 13 настай охины гэр бүлд туслах "Итгэлцлийн сүлжээ" хандивын аяныг Б.Ундрах гэх бүсгүй фэйсбүүкээр өрнүүлж, нэг сарын хугацаанд 30 гаруй сая төгрөг цуглуулж ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгсөн юм. Хандиваар цугласан мөнгөний 21 саяыг нь Монгол Улсын иргэд есөн саяыг гадаадад ажиллаж, амьдарч монголчууд болон гадаадын иргэд өгчээ. Охины гэр Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, бидний нэрлэж заншсанаар Дамбын эцэс гэх налуу ихтэй газарт байдаг аж. Тиймээс хандивын мөнгөний тодорхой хэсгээр хашааныхаа газрыг тэгшлүүлж, 8x7 м харьцаатай өвлийн дүнзэн байшингийн суурийг өчигдөр цутгасан байна. Үр хүүхдээ цаг бусаар алдахын гашуун зовлонг эдэлж, бие сэтгэлээрээ тарчилж яваа охины гэр бүл сайхан сэтгэлд ард түмнийхээ дэмжлэгээр ийнхүү шинэхэн байшинтай болж байна.

ИРЭХДЭЭ ШИЛЭН,



Б.БУНДХОРОЛ
batbund@gmail.com

Шилэн Цогоо ширэн Цогоо болохыг хардаг азтай хүнээ гэж баярлаж хөөрөх нь ч хаашаа юм. Азгүй хүнээ би гээд бархирчуйлах нь ч хаашаа юм. Анхлан миний мэдэхээр тэр жилийн сонгуулиар ФМ радиогийн хөтлөгч Цогоо намын хэвлэл мэдээлэлд оччихоод өрсөлдөгч намынхаа нэр дэвшигчийг гүтгэсэн гэж шоронд орж байлаа. Тэр үед бол хөтлөгч Цогоо, Шорон Цогоо болсон юм. Дараа нь Шилэн дансны хууль батлагдахтай зэрэгцэн өрсөлдөгч намынхаа дарга нартай аж ахуйн нэгжүүдийн тайлан тооцоог ухаж баахан манаргав. "Жиргэгчид" түүнд шилэн Цогоо хэмээх алдар хүртээв. Сайхан нэр шүү, шилэн Цогоо. Нам нь ялсан даруйдаа 60 тэрбумын схемээр түүнд дэд сайдын суудал өгсөн юм даг. Аан

эсвэл авсан юм даг. За эндээс л шилэн Цогоогийн шил хагарч, ширэн арьс нь ил гарсан хэрэг. Өнгө зүс нь хар болохоор тэгсэн үү, арьс үс нь үхэр, гахайн шир шиг байсан болоод тэгсэн үү? Аль эсвэл хийж хэрэгжүүлж байсан ажил нь ичмээр байхад өөрөө ширэн царайлсан болоод



ЯВАХДАА ШИРЭН

хүн шинэхэн авсан нэрэндээ зохицсон аятай ширэн царайлаад л тэс хөндлөн юм ярина. Саяхан Ерөнхий сайд хариуцлага алдсан хэмээн Зам тээврийн хөгжлийн яамны удирдлагуудыг ажлаас нь чөлөөлөхөд мань хүн "би уг нь сүүлийн үед үүсээд буй нөхцөл байдалтай шууд буюу шууд бус оролцоогүй хэдий ч ёс зүйн хувьд хариуцлага хүлээе" хэмээн бас л ширэн царайлав. Өөрийнх нь удирдлаганд байсан салбарт галт тэрэг онхолдож, газрын дарга нар нь архидаж, нэгнээ алж байхад "би шууд буюу шууд бус оролцоогүй" хэмээн яаж хэлж чадаж байна аа. Ёстой л ширэн Цогоо юм даа. Хамгийн сүүлд өчигдөр өөрийн хуудсанд төрийн ордонд инээгээд алхаж буй зургаа оруулаад "Нас минь залуу, дэлхий ертөнц уужим. Хариуцлага ёс зүйтэй төрийн төлөө ажиллах болноо" хэмээн бичжээ. Тэр хүнд өөрийнх нь удирдсан салбарт учирсан хохирол, хүний амь, ажлын алдаа түй ч хамаагүй бөгөөд ёс зүйн хариуцлага хүлээсэн гэдэг нэрээр ширэн нүүрлээд явлаа. Баяртай.

гэнээ, ширэн Цогоо. Хоолноос нь ялаа гарснаас болоод зарга хийж гэнээ, ширэн Цогоо. ЕБ-ын Сургууль төгсөөгүй гэнэ, ширэн Цогоо. Хуурамч дипломтой гэнэ, ширэн Цогоо. Галт тэрэг унаж гэнээ, ширэн Цогоо" гэх мэт үнэн, худал мэдээлэл өдөр бүр хөвөрнө. Харин мань

МЭДЭЭЛЭЛ

Д.Эрдэнэбат: УИХ тарах ёстой



Б.ПҮРЭВЖАВ
b.puuji11@gmail.com

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдөр ээлжит бусаар хуралдаж, цаг үеийн асуудал хэлэлцсэн байна. Энэ талаар УИХ өчигдөр Төрийн ордонд мэдээлэл хийв. Энэ талаар УИХ дахь бүлгийн дарга Д.Эрдэнэбат "Сүүлийн үед гарч буй үйл явдал Монголын төрийг чадамжгүй болгож байна. МАН-ын эрх баригчдын сүүлийн хоёр жилийн хугацаанд хийсэн үйлдэл, явуулсан бодлогогүй алхамууд төрийн нэр хүндийг бүрэн унагасан. Тиймээс У.Хүрэлсүхийн Засгийн газрыг огцруулах нь зүйтэй хэмээн үзсэн. "Төрийн бодлогогүй, шийдвэргүй, хариуцлагагүй, назгай үйл ажиллагааны улмаас сүүлийн үед нийгмийг цочроосон, бухимдуулсан асуудлууд шил даран гарч байна. 2016 оны УИХ-ын сонгуулийг 60 тэрбумаар үнэлэн үнэмлэхүй олонхийн суудал авсан МАН, төр, засгийн бүхий л эрх мэдлийг цөөн хэдхэн хүмүүсийн гарт төвлөрүүлж байгаа. Мөн Төмөр зам, "Эрдэнэт" үйлдвэр гэх мэт томоохон асуудалд гал унтраах төдийхнөөр хандаж, цөөн хүнд хариуцлага хүлээлгэсэн байдлаар олны анхаарлыг сарниулж буй Засгийн газрын оролдлыг Ардчилсан нам эрс эсэргүүцэж байна. Эрх баригчид УИХ-ын ээлжит бус чуулганыг нэн яаралтай хуралдуулж У.Хүрэлсүхийн тэргүүлсэн Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах асуудлуудыг нэн яаралтай хэлэлцэн шийдвэрлэхийг шаардаж байна. УИХ ээлжит бус чуулган хуралдуулж Засгийн газартаа хариуцлага тооцож чадахгүй бол УИХ өөрөө тарах ёстой гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэе" хэмээв.

TISSOT CHRONO XL. 4.45MM CASE

T + TISSOT

#ThisIsYourTime

TISSOTWATCHES.COM
TISSOT. INNOVATORS BY TRADITION

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

Доорх жагсаалтад нэр дурдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид Та бүхэн хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу төлбөрөө хугацаанд нь бүрэн төлж бүртгүүлэхийг тэдэгдье.

Table with 6 columns: №, Код, Эзэмшигч, Талбай (га), Олгосон огноо, Дуусах огноо. Contains 104 rows of mining license data.

Table with 6 columns: №, Код, Эзэмшигч, Талбай (га), Олгосон огноо, Дуусах огноо. Contains 173 rows of mining license data.

- 1 Та тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөө дараах дансанд тушаана уу.
2 Та холбогдох мэдээлэлээ http://mnam.gov.mn/ цахим хуудсаар орж танилцана уу.
3 Лавлагаа авахыг хүсвэл 263942 дугаарын утсанд хандана уу.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БАРЬЦААЛАГЧ БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

2018 оны 08 дугаар сард ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу бүрэн төлж бүртгүүлэхийг хүсье.

Table with 6 columns: №, Код, Эзэмшигч, Барьцаалагч, Талбай (га), Олгосон огноо. Contains 15 rows of bank-related mining license data.

- 1 Та тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөө дараах дансанд тушаана уу.
2 Та холбогдох мэдээлэлээ http://mnam.gov.mn/ цахим хуудсаар орж танилцана уу.
3 Лавлагаа авахыг хүсвэл 263942 дугаарын утсанд хандана уу.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

Company information block including: ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ: Б.ОЮУНГЭРЭЛ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ: Б.ӨНӨРТӨГӨХ, УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, ГАДААД МЭДЭЭЛЛИЙН АЛБА: Б.ПҮРЭВЖАВ, МЕНЕЖЕРҮҮД: М.ДАВААДУЛАМ, ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИГГИЙН ДАРГА: Н.ПУНЦАГБОЛД, ФЭЙСБҮҮК: www.facebook.com/mmdardas/, ТВИТТЕР: www.twitter.com/mmdardas.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +21
Шөнө +16
Нөгөөдөр
Өдөр +20
Шөнө +13

ӨДРИЙН ЗУРХАЙ



НАМРЫН ТЭРГҮҮН ЦАГААН БИЧ САРЫН ШИНИЙН 3. ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ШАР БАР ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал баялаг төгөлдөр болно.

Наран ургах, шингэх:
05.46-20.06



Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, сүм дуганыг сэргээх, амьлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Гөлөг тэжээх, зодиг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр.

ӨДРИЙН ХҮН

УРАГШГҮЙ “НОЁН”



Б.ПҮРЭВЖАВ

УБТЗ ХНН-ийн дарга Д.Жигжиднямаад ичих нүүр алга. Хагас цэргийн зохион байгуулалттай, өндөр хариуцлагыг алхам тутамдаа шаардаж байдаг УБТЗ хэмээх байгууллагыг толгойлж эхэлснээс хойш өнөөг хүртэл хэл амгүй ажилласан тохиолдол байсангүй. Хэрвээ түүнд ичих булчирхай байсан бол зөвхөн Улаанбаатар-Сайншанд чиглэлд явж байсан суудлын 286 дугаар галт тэрэгний осол Д.Жигжиднямаагийн ажлаа хүлээлгэн өгөх шалтгаан байлаа. Энэхүү ослоос болж 300 гаруй хүн хохирч, хоёр хүн эмнэлгийн орон дээр үхэлтэй тэмцэж байхад Д.Жигжиднямаа албан тушаалтайгаа үлдэхийн тулд өргөдлөө өгөөгүй гэсэн мэдэгдлийг цацаж, гаргасан алдаагаа засаж, залруулахын тулд хичээж байна гэсэн утга бүхий тунхаглалыг УБТЗ-аас гаргаж байх жишээтэй. Мөн авлига, албан тушаалын наймаа, хууль бус томилгоо, 100 вагоны шахаа гээд түүнийг тойрсон хэл

ам одоо хэр нь намжаагүй. АТГ-ын хаалга татан түүнд хаягласан гомдол өнгөрөгч хаврын өдрүүдэд цуварч, одоо хэр нь хэргийн зангилаа тайлагдаагүй байна. Сануулбал, 2017 оны хоёрдугаар сард зам засварын машин худалдаж авсан байдаг. Тэрбээр үүнийг худалдаж авахдаа Английн компаниар зуучлагч хийлгэн, машиныг хоёр дахин өндөр өртгөөр авсан асуудалд шалгагдаж байгаа юм. Тухайн машин нь 60 сая рублийн үнэтэй гэдгийг үйлдвэрлэгч компани мэдэгдсэн ч тухайн үеийн ханшаар бол сая ам.доллар хүрэхгүй. Гэтэл Английн компаниар дамжуулан нэг сая 770 мянган ам.доллараар энэ машиныг худалдан авсан тухай мэдээлэл байдаг. Үүнээс Д.Жигжиднямаа 770 мянган ам.доллар буюу тэрбум гаруй төгрөгийг зувчуулсан байж болзошгүй хэмээн АТГ-т шалгагдаж байгаа ч өнөө хэр нь шийдэгдээгүй байна. Тиймээс ажил үүргээ биелүүлж чадаагүй урагшгүй “ноён”-д хариуцага тооцож, УБТЗ ХНН-ийг аварья.

ӨӨР ӨНЦӨГ

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

Хэдэн жил бороо хүссэн монголчуудын хүслийг хурмаст тэнгэр сонссон бололтой. Энэ жил бага зэрэг оройтсон ч үүл гараад л бороо орж байна. Энд тэндгүй л үер ус буугаад байгаа. Ёстой л хүссэн юм хүзүү орооно гэдэг болж, бороо ч нэг шаагиж байна аа. Нэг гэм нь борооны улмаас эвдрээгүй зам энэ улсад бараг л үлдсэнгүй. Япончууд нууц технологиор “Нарны зам”-ыг барьсан тулдаа л нэг тэсэж байх шиг байна. Манайхны тавьсан замууд

Бороонд баярлалаа

нэг шөнийн бороонд тэр чигээрээ урсаад алга болчихлоо. Хот хоорондын замууд суурьтайгаа урсаад явчихаж байна. Бүр төмөр зам хүртэл урсч, галт тэрэг осолдов. Харин манай замын салбарынхан, удирдлагууд, сайд, дарга нар нь бороонд буруу өгч, мэддэг бүх хараалаа урсаж сууна. Аргагүй дээ, борооноос болж байдгаа барж байж олж авсан суудлаа алдаж байгаа хойно. Зарим хүмүүс ч бороонд буруу өгч, зам барьдаг хүмүүс, тендер цавчдаг дарга нараа өмөөрөх шинжтэй. Харин ч их бороо орж байгаад баярлах хэрэгтэй. Болдог бол

“бороо тандаа баярлалаа” гэж очиж мөргөмөөр байна. Тендерээ цавчаад, замаа нимгэлээд, нарийсгээд “идчихдэг” нөхдүүдийн бөгсөн дээр нь бүлээн жин тавьж, хэдхэн минутын ширүүн бороонд урсдаг замтай улс гэдгийг харуулж өгсөнд нь баярлах хэрэгтэй. Цаашид ч гэсэн бороо үргэлжлээд ороод байгаасай. Нэг мөр бүх зүйлийн чанарыг шалгах хэрэгтэй. Түүний дараа дарга нар хоногийн бороонд урсчихгүй зам тавих ухаан суух байлгүй дээ.



twitter

Элийрэгч @Uyanga_ts
Хамгийн өөдгүй жуулчид бол Солонгосууд гэж хэлээ биз дээ? Со компаниар дамжаад со онгоцондоо суугаад со буудалд буугаад со ресторандаа ороод со тур операторынхаа со гэр камп руу явдаг. Монголчуудад ганц ч мөнгө дусагнуулахгүй дээ харинч... Со малчин, со морь л гэж алга одоохондоо

Temuijin Kh @Temuijin_Kh
65 суудалтай хэт олонхи болсон улс төрийн хүчинг тэхий дундуур нь хуваагаад хэрүүлээс өөр ажилгүй бүрэн эрхийг нь таллана гэдэг гайхамшиг юм! 65 суудалтай атлаа хоёр талцаад хошноогоо ухалцахаас илүү гарахгүй бүрэн эрхээ барана гэдэг Ардын засаг, Ардын намдаа таарсан гутамшиг юм!

WITCH @burmaa87
Шөнийн ээлжинд жижүүрлэж хоносон эмч ээлжнээсээ буугаад хувийнхаа приусээр таксид явжышд. Баян, хангалуун амьдрах гэж биш амжиргаагаа залгуулах гэж...

facebook

Нийслэлийн Газрын алба
#БҮТЭЭН_БАЙГУУЛАЛТЫН_АЖЛЫН_ГАЗАР_ЧӨЛӨӨЛӨЛТ_ХИЙГДЭЖ_БАЙНА
БГД-ийн 17 хорооны нутаг дэвсгэрт хийгдэж буй Эрүүл мэндийн 7 дугаар төвөөс 70/2 дугаар байр хүртэлх шинээр тавигдаж буй авто замын нөлөөлд өртсөн хэсэгт зөвшөөрөлгүй байрлуулсан гаражуудыг буулгаж, газрыг чөлөөллөө.

ТЭНГИС КИНО ТЕАТР

Movie posters for various films including Rampage, Skyscraper, and others.

Тун Удахви

Movie posters for films like The Last Days of Paddy Stone, The Day After Tomorrow, and others.

Оффөөөн ёёзгә Оүй аёйууи

Тасалбар захиалах утас: 7605-3131